

## ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛАВ

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Европ судлалын секторын эрхлэгч, МУИС-ийн Улаанбаатар сургуулийн докторант Харцага овогт Дашнямын Золбоогийн “Монгол, Британий харилцаа (улс төр, эдийн засаг, соёлын харилцаа)” сэдвээр Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалуулах эрдмийн зөвлөлийн хурал 2011 оны 10-р сарын 28-ны өдөр МУИС-ийн Хичээлийн 1-р байрны 320 тоот өрөөнд амжилттай болж өнгөрлөө. Академич, доктор Ч.Болдбаатар даргатай Түүх, археологийн чиглэлээр докторын зэрэг хамгаалуулах Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 100 хувийн санал авсан уг диссертаци зохиол нь удиртгал, 3 бүлэг, 7 зүйл, дүгнэлт, эшлэсэн материал, хавсралт, ном зүй, нэрийн хэлхээгээс бүрдэх нийт 139 хуудас юм.

Судлаач хоёр орны харилцааны түүхийг дипломат харилцаа тогтоохоос өмнөх үеийн харилцаа буюу 1963 оноос өмнөх үе, дипломат харилцаа тогтоосон хийгээд түүний дараах үе буюу 1963-1990 он хүртэлх үе, ардчилал шинэчлэлийн үеийн харилцаа буюу 1990 оноос өнөөг хүртэлх үе хэмээн ерөнхийд нь 3 үечлэн хуваан үзсэн бөгөөд зохиол нь үе тус бүрийг онцлог шинжийг агуулсан 3 бүлгээс бүрдэж байна. Үүнд, I бүлэг Монгол, Британий түүхэн уламжлалт харилцаа Түүхэн харилцааны эрт үе, XX зууны эхэн үеийн харилцаа: “Монгол, Британий хооронд дипломат харилцаа тогтсон нь, түүний дараах үеийн харилцаа (1963-1990)”, II бүлэг Дипломат харилцаа тогтоох урьдчилсан нөхцөл бүрдсэн тойм, Дипломат харилцаа тогтсон нь, харилцааны анхны алхмууд хэрэгжиж эхэлсэн нь: “Монгол, Британий харилцааны шинэ үе (1990 оноос хойш), III бүлэг Улс төр, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа, Британийн тусламж, хүмүүнлэгийн харилцаа, Харилцаа, хамтын ажиллагааны шинэ чиг хандлага гэсэн хэсгүүдээс бүрдсэн байна.

Хоёр орны харилцааны сүүлийн 100 гаруй жилийн түүхэн үйл явцыг он цагийн дарааллаар үечлэн, үе тус бүрийн онцлогийг тухайн нийгмийн байдал, олон улсын харилцааны ерөнхий чиг хандлагатай холбон судалж өөрийн үнэлэлт дүгнэлт өгснөөрөө, мөн харилцааны түүхтэй холбоотой Монгол Улсын архивын хэрэглэгдэхүүнийг анх удаа олны хүртээл болгож, Британи болон бусад улсад хэвлэгдсэн сурвалж судалгааны бүтээлүүдийг өргөн ашиглаж, эрдэм шинжилгээний эргэлтэнд анх удаа оруулснаараа энэ ажил шинэлэг талтай болсон байна.

Доктор Д.Золбоо судалгааны ажлын урьдач болгон 2005 онд хэвлүүлсэн “Монгол, Британий харилцаа” бүтээлийнхээ шинэчлэн найруулсан хоёр дахь хувилбараа ойрын үед хэвлүүлэхээр ажиллаж байна.